

Аман орчуулгын Үйлчилгээний Талаар Байнга Асуугддаг Асуултууд

Банк англи хэлний мэдлэг хязгаарлагдмал харилцагчдад аман орчуулгын үйлчилгээ санал болгодог уу?

Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авч буй бүх харилцагчдад шударга байж, ялгаваргүй хандах боломжийг олгохын тулд Банк хоёр буюу Испани хэлтэй ажилтнуудыг ажиллуулдаг. Бусад хэлний хувьд Банк бие даасан гуравдагч талын үйлчилгээтэй бөгөөд англи хэлгүй хүмүүст олон хэлний орчуулгын үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн хүмүүсийг утсаар холбож өгдөг.

Ямар хэл ашиглах боломжтой вэ?

Ихэнх тохиолдолд хүмүүс Испани, Солонгос, Бразил-Португал, Мандарин, Балба, Монгол, Араб хэлээр тусламж авахыг хүсдэг. Гэхдээ манай аман орчуулгын үйлчилгээ хэдэн зуун хэл, аялгаар үйлчилгээ үзүүлнэ.

Орчуулгын үйлчилгээг ашиглахад төлбөртэй юу?

Үгүй ээ, банкны харилцагчдаас орчуулгын үйлчилгээ ашигласны төлбөр авдаггүй.

Би аман орчуулгын үйлчилгээ хэрхэн хүсэх вэ?

Хэрэв танд асуулт байгаа бол эсвэл англи бус хэл дээр нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй 888-672-5626 утсаар холбогдоорой, бид орчуулагч нартай утсыг түргэн шуурхай дамжуулах болно.

Банк англи хэлнээс бусад хэл дээр орчуулсан бичиг баримт өгдөг үү?

Холбооны болон мужийн хуулиар шаардвал эсвэл хөрөнгө оруулагчдын удирдамжид заасан тохиолдолд бид англи хэлнээс бусад хэл дээр орчуулагдсан мэдээллийг өгдөг. Одоогийн байдлаар бид англи хэлнээс бусад хэлээр банкны үйлчилгээ үзүүлэх, зээлийн үйлчилгээ үзүүлэх, өгөх боломжгүй байна.

Банкны орчуулгын үйлчилгээний чанарыг чанарын стандартаар үнэлдэг үү?

Манай орчуулгын үйлчилгээ баталгаат аман орчуулагчдыг ажиллуулдаг бөгөөд Олон улсын стандартын байгууллага (ISO)-ын жишиг стандартыг дагаж мөрддөг:

- 9001:2015 Чанарын менежментийн системийн үйлчилгээ нь хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол хангах чадвараа харуулахыг шаарддаг.
- 13611:2014 Олон нийтийн орчуулга хийх удирдамжийн үйлчилгээ нь хэлний мэдлэг багатай хүмүүст үйлчилгээ авах боломжийг олгохын тулд аман болон бичгэн харилцааны явцад орчуулга хийх шалгуур үзүүлэлт маш сайн байж, шилдэг туршлагыг бий болгохыг шаарддаг.
- 17100:2015 Орчуулгын үйлчилгээ нь чанартай орчуулгын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай үндсэн процесс, нөөц болон бусад талын шаардлагатай хэрэгцээг хангахыг шаарддаг.

Миний мэдээллийг хамгаалахын тулд ямар арга хэмжээ авдаг вэ?

Банк мэдээллийн аюулгүй байдал, таны хувийн мэдээллийн нууцлалыг маш нухацтай авч үздэг. Олон нийтэд нээлттэй бус таны хувийн мэдээллийг хамгаалахын тулд аман орчуулагчдад нарийвчилсан шалгалт авах журмыг хэрэгжүүлж, албан ёсны Мэдээллийг задруулахгүй, нууцлах гэрээнд гарын үсэг зуруулах шаардлагатай байдаг.